



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 29 өдөр

Дугаар 4/125

Батноров сум

**Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын
ажлыг зохион байгуулах тухай**


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал, амьтны Эрүүл мэндийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.2, 5.1.3, 5.1.4, 5.1.5 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1, 6.4, 6.5, 6.6, дэх хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.4, 9.5, 9.6, 9.7 дахь хэсэг, 9.8.1, 9.8.2 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.2, 28.4 дэх хэсэг, Малчны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.5 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, Хэнтий аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2025 оны 07 дугаар сарын 25-ны А/43 тоот тушаал, Аймгийн Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 25-ны А/435 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зооноз, архаг халдварт малын бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад Сумын хэмжээнд нийт охин төл малыг бүрэн хамруулах ажлыг 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэлх хугацаанд чанартай хийж гүйцэтгэхийг Дэлгэрэхсүрэг ХХК-ий захирал А.Мөнхбаяр, “Бөмбөг шарга” ХХК-ий захирал (Б.Баясгалан), “Мааньт хөхий” ХХК-ий захирал (Ш.Эрдэнэчимэг), “Энхсүрэг” ХХК-ний захирал (Г.Өсөхбаяр), “Ажнай вит” ХХК-ний (С.Болдбаатар), Малын их эмч (Н.Мөнхтуяа), Хувирахуй ХХК-ний захирал М.Алтанчимэг нарт тус тус үүрэг болгосугай.

2. Дархлаажуулалтад хамрагдах өрхийн судалгааг гаргаж, тарилга хийх хашаа хоолойг бэлтгэн, мал сүргээ бэлэн байлгах ажлыг урьдчилан мэдэгдэж, зохион байгуулж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид мал бүхий иргэд заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Т.Жаргалцэцэг)-д, хариуцуулсугай.

4. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжөөр хангах, ажлын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох газарт цаг хугацаанд нь мэдээ, мэдээллийг хүргэж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (Т.Жаргалцэцэг)-д, Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Бямбацогт)-д үүрэг болгосугай.

ДАРГА  ОТГОНБАЯР

232530017